

Гүйцэтгэх захирлын 2015 оны
сарын-ны өдрийн/дугаар,
дүгээр/ тушаалын нэгдүгээр хавсралт

Дулааны шугам, тоноглолын засвар шинэчлэлтийн
ажилд техник хяналт тавьж ажиллах журам

УБДС ХК-ийн хөрөнгөөр хийгдэх 2015 оны зуны их засварын ажил болон төв шугам шинэчлэн солих ажилд техник хяналт тавих, өргөтгөл шинэчлэлтийн ажлыг их засварын батлагдсан графикт хугацаанд багтаан чанартай хийлгэхэд энэхүү журмын зорилго оршино.

Нэг. Ажиллах журам

1.1. Зуны засварын хугацаанд шугам, тоноглолын шинэчлэлтийн ажилд техник хяналт тавихаар Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон инженерүүд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Шинэчлэн солих болон өргөтгөх дулааны шугамын батлагдсан зураг схем, ажлын тоо хэмжээ эзлэхүүнийг Ашиглалтын алба, Цахилгаан эргэх механизмын албанаас тодруулж, гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг Инженерийн албанаас авна.

1.3. Хяналтын инженер нь ажил гүйцэтгэхээр шалгарсан компанийг ажил гүйцэтгэх гэрээ, ажлын график гарган захиалагч байгууллагаар хянуулж, батлуулсан байхыг шаардаж хийлгэнэ.

1.4. Дулааны шугамд тавигдах шугам хоолой, тоног төхөөрөмжүүд нь шинэ байхаас гадна дулааны шугамын стандарт, тендерийн болон техникийн шаардлагын дагуу шулуун оёдолтой эсвэл оёдолгүй байна. Шинээр тавигдах шугам хоолой, хаалт арматуруудыг Эрчим хүчний хөгжлийн төвийн металл судлал гагнуурын лабораториор үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулна.

1.5. Дулааны шугамд тавигдах төмөр бетон хийцүүд нь зурагт заагдсан зуурмагийн маркийг хангаж байх ба түүнийг бичиг баримтаар баталгаажуулна. Үүнээс гадна цементээр хийгдэж буй эд ангиудыг зориулалтын лабораторт шалгуулж баталгаажуулсан байна.

1.6. Гүйцэтгэгч компани нь Эрчим хүчний хөгжлийн төвийн металл судлал гагнуурын лабораторитай гэрээ хийлгэн, шугам хоолойн угсралтын гагнуурын оёдлыг, шалгуулж дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлд хавсаргана.

1.7. Гүйцэтгэгч компани нь шугам угсралтын ажил эхлэхээс өмнө Ашиглалтын албаны шугам хариуцсан инженертэй хамтран солигдох шугамын хамгаалалтын зурвас талбайг чөлөөлөх арга хэмжээ авч, ажлын талбайг бэлтгэн, хот тохижилт, цахилгаан, холбоо, ус суваг, замын цагдаа болон авто замын газар зэрэг байгууллагаас ажил эхлэх зөвшөөрөл авсан байна.

1.8. Ажлыг гүйцэтгэх үеийн угсралт монтажийн явцыг фото зургаар баримтжуулж, маргаантай асуудлыг ерөнхий инженерт танилцуулан гүйцэтгэгч байгууллагатай хамтран цаг алдалгүй шуурхай шийдвэрлүүлж, баримтыг өөрийн хяналтын тайланд хавсаргана.

*Дулааны шугам, тоноглолын засвар шинэчлэлтийн
ажилд техник хяналт тавьж ажиллах журам*

1.9. Хяналт тавьж буй инженер техникийн ажилтнууд нь гүйцэтгэгч компанийн талбайн инженер, ерөнхий инженер, удирдлагад үзлэг хийсэн тухай бүрт өөрийн үзлэгийн дэвтэртээ гарын үсэг зуруулж баталгаажуулна.

1.10. Шугам хоолойг буулгаж эхлэхийн өмнө Эдийн засаг санхүүгийн алба болон Ашиглалтын албаны холбогдох ажилтнуудтай хамтран тооллого хийж, заасан газруудад буулгасан хуучин шугам хоолойн дулаалгыг хуулан авч, буусан хаалт арматурыг няравт хүлээлгэн өгч, шинээр угсралт хийж буулгасан материалуудад бүртгэл хөтөлж байна.

1.11. Техникийн хяналт тавьж байгаа инженер техникийн ажилтнууд нь дулааны шугам хоолойн шинэчлэлийн ажлын явцад угсралт буруу хийх, шаардлага хангахгүй материал нийлүүлж буй тохиолдолд ажлыг зогсоон түүнийг гүйцэтгэгч компанид мэдэгдэн шуурхай засуулах арга хэмжээ авна. Энэ тухай захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын удирдлагад мэдэгдэн фото зураг, акт протоколоор баталгаажуулан албан бичгээр шаардлагыг өгнө.

1.12. Дулааны шугамын угсралт шинэчлэлтийн ажлыг батлагдсан графикт хугацаанд нь чанартай хийлгэж, тухайн дүүргийн Төхижилт үйлчилгээний компани, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлээс төхижилтын ажлыг гүйцэтгэж бүрэн дууссан тухай албан бичиг авахуулж ажлын гүйцэтгэлийг гаргуулна.

1.13. Дулааны шугам шинэчлэлтийн ажлын хэмжээнд ороогүй зайлшгүй хийгдэх ажлыг ерөнхий инженерт танилцуулж, гүйцэтгэгч компанийн захирал, ерөнхий инженерийг байлцуулан протокол үйлдэн баталгаажуулж, магадлашгүй ажлын зардалд багтаан хийлгэнэ.

1.14. Гүйцэтгэгч компаниар шинээр хийсэн дулааны шугамын угаалт шахалтын схемийг гарган захиалагчаар батлуулж, гүйцэтгэх ажлыг аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу чанартай хийлгэнэ.

1.15. Дулааны шугам, насос станцын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг батлагдсан зургийн дагуу хийгдэж байгаа эсэхэд ажлын бус цагаар байнгын хяналт тавьж тусгай тэмдэглэл хөтлөн тайлан бичиж Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженерт танилцуулна.

Хоёр. Шагнал урамшуулал:

2.1. Дулааны шугамын засвар шинэчлэлтийн ажлын техник хяналтыг сайн хийж, ажлыг хугацаанд нь чанартай хийлгэсэн нөхцөлд илүү цагийн урамшуулал, хяналтын зардал олгох асуудлыг ажлын гүйцэтгэлээс хамаарч Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гурав. Хүлээх хариуцлага:

3.1. Шугам хоолой өргөтгөн шинэчлэх ажилд техник хяналт тавьж буй инженер техникийн ажилтнууд нь өөрсдийн хайхрамжгүйгээс дулааны шугамын техник ашиглалтын дүрмийн шаардлага хангахгүй шугам, тоног төхөөрөмжийг угсралтын ажилд монтажлах, буулгаж хүлээж авах, материалыг няравт хүлээлгэн өгөөгүй, угсралтын ажлыг дутуу хийлгэсэн, шугамын зогсолтыг засварын графикт хугацаанаас хоцроосон тохиолдолд байгууллагын дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

